



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 17/421

Арвайхээр


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.17, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 01/02 дугаар тогтоолоор батлагдсан “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Бүтээлч Өвөрхангай-2020 хөтөлбөрийн 4.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Ахмадын хорооноос эмхтгэн гаргаж буй “Түүхийн гэрч ахмад үе” (хоёрдугаар дэвтэр) номыг хэвлүүлэхэд дэмжлэг үзүүлж 3.200.000 (гурван сая хоёр зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлыг төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100900